



Жишээлбэл, Анар 25 настайдаа усанд сэлэлтийн мэргэжлийн хүн болохыг зорилоо, үүнд мөнгө хэрхэн тус болох вэ?

- усанд сэлэлтийн хувцас
- усанд сэлэлтийн сургалтын төлбөр
- эрүүл мэндэд тустай витамин, амин дэм худалдан авах зардал
- туршлагтай багшаас хичээл авах зардал.

Таны мэдлэгт- Мөнгө хэдийгээр хүчтэй ч мөнгөөр авч болохгүй, мөнгөөр үнэлэх боломжгүй олон зүйлс бидний амьдралд байдаг. Жинхэнэ найз нөхөд, хайр сэтгэл, хайртай ээж аав, хөөрхөн дүү, гэр бүлээ мөнгөөр худалдаж авч болох уу. Авьяас билэг, оюун ухаан, хүн чанар, нэр хүндийг мөнгөөр худалдаж авч болох уу. Дэлхийн хамгийн их мөнгөтэй хүн цаг хугацааг буцааж болох уу... Та нар энэ талаар ямар бодолтой байна вэ?